



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/569

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Замын сангийн хөрөнгө оруулалтаар “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд 8, 9, 10 дугаар сард зарцуулах зардалд зориулан 9 650 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 9 650 000 төгрөг /есөн сая зургаан зуун тавин мянга/-ийг аймгийн Замын сангийн 4.9-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 01-ний өдрийн
А/569 дүгээр захирамжийн хавсралт

“Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын
хүрээнд зарцуулах зардал

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /90 хоног/	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1.	Хогийн цэгт ажиллах шатахууны зардал	л	3600	1750	6 300 000
2.	Тос, масло, сэлбэг	багц	1	2000000	2 000 000
3.	Хөдөлмөр хамгааллын зардал	Хүн/өдөр	90	5000	450 000
4.	Жолоочид урамшуулал, хоолны зардал	Хүн/өдөр	90	10000	900 000
Нийт					9 650 000

-oOo-